Танин мэдэхүйн хүрээний бууралтыг судалсан нь

Ч.Батдолгор, М.Булганхишиг, М.Энхтуяа, П.Баярмаа, Ж.Мөнхсайхан

Улсын Хоёрдугаар Төв Эмнэлэг,
Цахим хаяг: chuluunbaatarbatdolgor@gmail.com, Утас: 95283633

Түлхүүр үг:
Танин мэдэхүйн хүрээний бууралт
Альцгеймерийн өвчин
Тэнэгрэл

Товч утга: MocA (Montreal cognitive assessment болон MMSE (Mini-mental state examination сорилууд нь танин мэдэх үйл ажиллагааны хөнгөн, дунд, хүнд зэргийн бууралтыг илрүүлдэг, зонхилон хэрэглэгддэг аргууд юм. Танин мэдэхүйн хүрээний бууралт нь цаашид бүрэлдэн хөгжиж тэнэгрэлд хүргэх ба тэнэгрэл хэмээх ойлголтыг дэлхийн эрүүл мэндийн байгууллага тодорхойлохдоо бодож сэтгэх, эргэн санах, учир шалтгаанд дүгнэлт хийх хийгээд өөрийн зан чанарт хяналттай хандах цогц чадваруудын бууралтаар илэрхийлэгддэг эмнэлзүйн хам шинжүүдийн нийлбэр хэмээжээ. Тэнэгрэл нь өндөр настай хүмүүст ихэвчлэн тохиолддог хэдий ч наслалтын хэвийн явц биш юм. Үйлчлүүлэгчид дээрхи хоёр сорилыг хавсран хийсэн нийт 81 тохиолдлыг сонгож үр дүнг SPSS-22 программыг ашиглан тооцоолол хийсэн. MocA сорилын үнэлгээнд ≤25 оноог танин мэдэхүйн хөнгөн зэргийн бууралт хэмээн үнэлдэг бол MMSE сорилд ≤24 оноог энэ зэрэгт хамааруулан үнэлдэг. Судалгааны үр дүнд MoCa сорилд 88.9% (n=72), MMSE сорилд 48.1% (n=39) танин мэдэх үйл ажиллагааны бууралт байгаа нь тооцоологдсон байна. Цаашид танин мэдэх үйл ажиллагааны алдагдлыг илрүүлдэг өндөр ач холбогдол бүхий сорилуудыг тогтмол хэрэглэж, оношилгоо үйлчилгээндээ нэвтрүүлэх шаардлагатай.

Үндэслэл: Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээлж буй тархвар судалалын судалгаа 2015 оны байдлаар нийт 47.7 сая хүнд тэнэгрэл өвчин оношлогдсон нь батлагдсаныг мэдээлсэн бол цаашид энэ тоо нэмэгдсээр 2020 онд 135.46 сая хүнд хүрнэ хэмээн урьдчилан таамагласан байна.[1]

Уг өвчнөөр 4.1 секунд тутам нэг хүн өвчилж, нийт тохиолдлын 46% Азид оношлогдсон байдаг бол Ази хүмүүсийн уг өвчнөөр өвдөх дундаж наслалт 75-84 нас хэмээн тогтоожээ.[2]

Бага-дунд орлоготой орнуудын хувьд тэнэгрэлд дотоодын нийт бүтээгдэхүүний 1%-г зарцуулж байгаа бөгөөд тархалт болон хүндрэлийн зэргээс хамааран цаашид ч өсөх хандлагатай байна.[3]

Монгол улсад тэнэгрэл болоод түүнийг нөхцөлдүүлэгч гол шалтгаан, тархварзүйн талаархи томоохон судалгаа хийгдээгүй байна. Манай улсад эрүүл мэндийн байгууллагууд, ялангуяа мэдрэл судлалын салбарт танин мэдэх хүрээний үйл ажиллагааг үнэлэх олон сорилуудыг нэвтрүүлэн хэрэгжүүлж байгаа боловч цаашид үр дүн өндөр сорилуудыг илүү түлхүү хэрэглэн, уг өвчнийг эрт оношлох шаардлагатай байна.

Зорилго: Улсын Хоёрдугаар Төв Эмнэлгийн мэдрэл судлалын тасагт нэвтрүүлэн, үйлчлүүлэгчдийн танин мэдэхүйн үйл ажиллагааг үнэлж буй MocA (Montreal cognitive assessment) болон MMSE (Mini-mental state examination)-д дүгнэлт хийж цаашид үр дүн өндөр сорилыг үргэлжлүүлэн үнэлгээнд ашиглан танин мэдэх үйл ажиллагааны алдагдлыг эрт илрүүлэхэд оршино.

Зорилт:
1. Судалгаанд оролцогсдын сорилд нийгэм хүн ам зүйн үзүүлэлтийг тодорхойлох
2. Судалгаанд оролцогсдод хийгдсэн хоёр төрлийн сорилд харьцуулан дүгнэлт хийх

Хэрэглэгдэхүүн, арга аргачлал: 2019 оноос 2020 онд УХТЭ-ийн мэдрэл судлалын амбулатори болон хэвтэн эмчлүүлэх тасгаар үйлчлүүлэгчдэд MocA болон MMSE сорилыг хавсарч хийсэн тохиолдлуудыг бүртгэн судалсан. Үйлчлүүлэгчид дээрхи хоёр сорилыг хавсран хийсэн нийт 81 тохиолдлыг сонгож үр дүнг SPSS-22 программыг ашиглан тооцоолол хийсэн. MocA сорилын үнэлгээнд ≤25 оноог танин мэдэхүйн хөнгөн зэргийн бууралт хэмээн үнэлдэг бол MMSE сорилд ≤24 оноог энэ зэрэгт хамааруулан үнэлдэг.

Үр дүн: Судалгаанд нийт танин мэдэх үйл ажиллагааны бууралт байж болзошгүй хэмээн сэжиглэгдсэн 81

үйлчлүүлэгчдэд МосА болон MMSE сорилыг хавсран хийсэн тохиолд тооцоолол хийснээс 54.3% (n=44) эрэгтэй, 45.7% (n=37) эмэгтэй, дундаж нас 67.7± 9.3, боловсролын түвшингээр харьцуулбал 70,4% (n=57) дээд, 29.6% (n=24) дунд болон бүрэн бус боловсрол эзлэж байна.

Судалгааны үр дүнд МоСа сорилд 88.9% (n=72), MMSE сорилд 48.1% (n=39) танин мэдэх үйл ажиллагааны бууралт байгаа нь тооцоологдсон байна.

Судалгааны дүнгээс харахад МоСа сорилд танин мэдэхүйн бууралтгүй 11% (n=9) танин мэдэхүйн хөнгөн зэргийн бууралттай 50.6% (n=41) танин мэдэхүйн хөнгөн дунд зэргийн бууралттай 32.1% (n=26), танин мэдэхүйн хүнд зэргийн бууралттай 6.2% (n=5) байсан бол MMSE сорилд танин мэдэхүйн бууралтгүй 53.1% (n=43), танин мэдэхүйн хөнгөн зэргийн бууралттай 30.9% (n=25), танин мэдэхүйн дунд зэргийн бууралттай 16% (n=13), байсан бол танин мэдэхүйн хүнд зэргийн бууралт үнэлэгдээгүй байна. (Зураг 1)



Зураг1.МосА болон MMSE сорилын харьцуулсан дүн

Танин мэдэхүйн бууралт нь насны (p value=0.034) хамааралтай байна.

Хэлцэмж: Жил ирэх тутам танин мэдэх үйл ажиллагааны бууралттай хүний тоо ихсэж байгаа ба Монголд танин мэдэх үйл ажиллагааны бууралтын нарийн судалгаа байхгүй хэдий ч тохиолдлын тоо өндөр байх хандлагатай байгааг манай судалгааны үзүүлэлт харуулж байна.

Паула нарын судалгаанд МоСа болон MMSE нь танин мэдэхүйн үйл ажиллагааны бууралтыг илрүүлэх хэдий ч МоСа сорил танин мэдэхүйн бууралтыг илрүүлэхэд илүү үр нөлөөтэй байгаа судалгааны үр дүн нь манай судалгааны үзүүлэлттэй мөн дүйцэж байна.

Танин мэдэх үйл ажиллагааны бууралт нас ахих тутам илүү тохиолдож байгаа судалгааны үзүүлэлт нь манай судалгааны дүнтэй мөн тохирч байна.

Дүгнэлт:

1. Танин мэдэх үйл ажиллагааны алдагдал нь зөвхөн өвчтөнд бус тэдний ар гэр, асран хамгаалагчид болоод нийгэмд асар их хохирол үзүүлж, цаашид тархалт өсөх хандлагатай байгаа эмгэгүүдийн нэг бөгөөд эрт оношилж тохирсон эмчилгээ үйлчилгээ үзүүлэх нь цаашдын хүндрэлд хүргэхгүй байх ач холбогдолтой юм.
2. Иймээс цаашид танин мэдэх үйл ажиллагааны алдагдлыг илрүүлдэг өндөр ач холбогдол бүхий сорилуудыг тогтмол хэрэглэж, оношилгоо үйлчилгээндээ нэвтрүүлснээр өвчтөн хийгээд, нийгэм эдийн засагт учрах сэтгэл хохирлыг бууруулах ач холбогдолтой юм.

Талархал: Уг судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд гүн тусалцаа үзүүлсэн. Мэдрэл судлалын тасгийн хамт олон; Мэдрэл судлалын тасгийн их эмч Ж.Мөнхсайхан; Мэдрэл судлалын тасгийн резидент П.Баярмаа; Тасгийн арга зүйч М.Энхтуяа; Сувилагч М.Булганхишиг нарт гүн талархал илэрхийлье.

Ном зүй:

1. Anna Ponjoan Josep Garre-Olmo. (2019 Mar 4). Epidemiology of dementia: prevalence and incidence estimates using validated electronic health records from primary care. Clin Epidemiol.
2. Ayda Rostamzadeh (2020 Apr 16). Early detection of Alzheimer's disease and dementia prediction in patients with mild cognitive impairment : Summary of current recommendations]. Nervenarzt.
3. Wortmann, M. (21 September 2012). Dementia: a global health priority - highlights from an ADI and World Health Organization report.
4. Katie Irwin(2018 Sep 19). Healthy Aging and Dementia: Two Roads Diverging in Midlife? Front Aging Neuroscience.
5. Paula T. Trzepacz, (2015 Sep 7). Relationship between the Montreal Cognitive Assessment and Mini-mental State Examination for assessment of mild cognitive impairment in older adults. BMC Geriatr.
6. Roberta Biundo (06 February 2016). MMSE and MoCA in Parkinson’s disease and dementia with Lewy bodies: a multicenter 1-year follow-up study. Neurology and Preclinical Neurological Studies - Original Article.
7. Rostamzadeh (2020 Apr 16. doi: 10.1007/s00115-020-00907-y). [Early detection of Alzheimer's disease and dementia prediction in patients with mild cognitive impairment : Summary of current recommendations]. Epub ahead of print.
8. Trey Hedden (2004 Feb). Insights Into the Ageing Mind: A View From Cognitive Neuroscience. Nat Rev Neuroscience.
9. Wortmann, M. (21 September 2012). Dementia: a global health priority - highlights from an ADI and World Health Organization report.

Study of cognitive decline

Batdolgor.Ch, Bulgankhishig.M, Enkhtuya.M, Bayarmaa.P, Munkhsaikhan.J

State Second Central Hospital
Email: chuluunbaatarbatdolgor@gmail.com, Tel:94117209

Abstract: The MosA (Montreal Cognitive Assessment) and MMSE (Mini-mental state examination) tests are the most commonly used methods for detecting mild, moderate, and severe cognitive impairment (Roberta Biundo, 06 February 2016). Decreased cognition leads to dementia, and the concept of dementia is defined by the World Health Organization as a set of clinical syndromes characterized by a decline in the ability to think, recall, reason, and control one's behavior (Wortmann, 21 September 2012). Although dementia is more common in the elderly, it is not a normal course of life. 2019 to 2020, a combination of MosA and MMSE tests was recorded in outpatient and inpatient neurology patients. The clients selected a total of 81 cases in which the two tests were combined and the results were calculated using spss-22 software. On the MosA test, a score of ≤25 is considered a mild cognitive decline, while on the MMSE test, a score of ≤24 is assigned to this degree. The study estimated a 88.9% (n = 72) decrease in cognitive function in the MoCa test and a 48.1% (n = 39) decrease in the MMSE test. In the future, high-value tests that detect cognitive impairment should be used regularly and introduced into diagnostic services.

Keywords: Cognitive impairment, Alzheimer's disease, Stupidity